БАТЛАВ:

НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.МӨНХБААТАР

БАГЦ 1: ХАН-УУЛ ДҮҮРЭГТ ГАЗРЫН ЗӨРЧИЛ АРИЛГАХ (ХАШАА, ХАЙС) АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 05 сарын 09-ний өдөр Дугаар № Улаанбаатар хот

1.	Газрын зөрчил арилгах ажлын даалгавар боловсруулах үндэслэл	Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3, 57.4 дэх заалт, Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5 дах заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09 дүгээр тогтоолоор батлагдсан "Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" -ийн 9 дүгээр зүйлийн 9.4.2 дах заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 23 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/414 дүгээр "Хууль, журмын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай" захирамж;
2.	Захиалагч байгууллага	Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба
3.	Захиалагчийн хяналт тавих байгууллага	Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба
4.	Ажлын үе шат	- Захиалагч байгууллагаас гаргасан зөрчил арилгах байршлын судалгаатай холбоотой зааварчилгаа авах; - Зөрчлийн байршилд захиалагчаас гаргасан хуваарийн дагуу буулгалт хийх; - Буулгалт хийгдсэн байршлын барилгын хог хаягдлыг зөөх, хаях; - Албадан хураагдсан эд зүйлийг харьяа дүүргийн Газар зохион байгуулалтын албаны журмын хашаа руу тээвэрлэж эд хариуцагчид хүлээлгэн өгөх; - Захиалагч байгууллагад буулгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, фото зургийг хүлээлгэн өгөх.
5.	Зөрчил арилгах байршил	Хавсралт жагсаалтад заасан **18 байршил**
6.	Ажлын тоо	Хавсралт жагсаалтад заасан **2804 (метр, тоо) зөрчил**
7.	Гэрээний хугацаа	Газар чөлөөлж, буулгалт хийх ажил, үйлчилгээний гэрээг тухайн жилийн эцсийн хугацаагаар байгуулах ба тухайн ажлын гүйцэтгэлийн чанараар гэрээг дүгнэж, цаашид гэрээг сунгах эсэхийг шийдвэрлэнэ.
8.	Тусгай зөвшөөрөл	Барилгын тусгай зөвшөөрөл
9.	Хүний нөөц	- Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер /үндсэн/ - Барилгын инженер (үндсэн болон гэрээт) - Инженер, техникийн болон бусад ажилчин (үндсэн

		болон гэрээт)
10.	Техникийн шаардлага (Тээврийн хэрэгсэл)	Гүйцэтгэгч нь экскаватор, ачааны машин (хово), маяти, портер, ковш, кран, шланз зэрэг тээврийн хэрэгсэлтэй байх эсвэл түрээсийн гэрээтэй байх, зөөврийн цахилгаан үүсгүүртэй байх.
11.	Болзошгүй эрсдэл	Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх хугацаанд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, журам, зааврыг баримтлан ажиллана. Журам, зааврыг зөрчсөнөөс үүдэн гарах бүх хариуцлагыг дангаар хүлээх үүрэгтэй. Захиалагчийн зааварчилгааны дагуу алдаа, дутагдал гаргалгүй, ажлыг хугацаанд нь гүйцэтгэнэ.
12.	Шаардагдах хөрөнгийн хэмжээ	Нийслэлийн төсвийн хөрөнгө – **93,940,000** (ерэн гурван сая есөн зуун дөчин мянга) **төгрөг**

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Текникийн болон санхүүгийн хосолсон оноо нь хамгийн өндөр гэж тооцогдсон байгууллагыг сонгож хэлэлцээрт урина. Сонгон шалгаруулалтад оролцсон байгууллагын чадвар, үнэлгээг тогтоохдоо Техникийн санал болон Санхүүгийн саналд дараах онооны системийг ашиглана.

А) Техникийн санал

№	Үнэлгээний шалгуур үзүүлэлт	Дэд үзүүлэлт	Оноо
1.	Байгууллагын ажлын туршлага	Ижил төстэй төрөл, хэмжээний ажил гүйцэтгэсэн туршлага.	20
2.	Арга зүй ба үйл ажиллагааны төлөвлөгөө	Барилга засвар хийх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байх.	10
		Үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөө нь ажлын даалгавар болон арга зүйтэй уялдсан байх. (Ажлын дараалал, хугацаа, хэрэгжүүлэхэд бодитой эсэх)	30
3.	Ажиллах хүчний товч намтар	Багийн бүрэлдэхүүн (Ажилтны товч намтар, сертификат, бусад бичиг баримт)	40
НИЙТ			**100**

Техникийн саналд (Т)-д 70-аас доош оноо авсан оролцогчийн саналыг цаашид үнэлгээнд ашиглахгүй.

Б) Хамгийн бага үнэ бүхий санхүүгийн санал (Рт)-д 100 оноо өгнө. Бусад санхүүгийн саналын оноог (F) дараах томьёогоор тооцоолж гаргана. F=100 x Рт/Р (F нь санхүүгийн оноо, Рт нь хамгийн доод үнэ, Р тухайн санхүүгийн саналын үнэ).

В) Санал өгсөн оролцогчийн нийт оноо (5) гаргахдаа Техникийн саналын хувийн жин (Т) болон Санхүүгийн саналын хувийн жинг (F) 70:30 харьцаагаар тооцож гаргана. Тухайн оролцогчийн үнэлгээний нийт оноо (5)-г дараах томьёогоор тооцоолж гаргана. 5=Т x 0.70+Fx 0.30

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

А) Гүйцэтгэгч нь буулгах, нүүлгэн шилжүүлэх, тээвэрлэх хэлбэрээр зөрчлийг арилгахдаа машин, техник хэрэгслийн сул зогсолт гаргалгүй, зохион байгуулалт сайтай ажиллах;

Б) Гүйцэтгэгч нь нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлөхдөө өөрийн ажилчид, холбогдох мэргэжлийн байгууллагын албан хаагч, мэргэжилтэн, цагдаагийн албан хаагчдын ажлын цагийг уялдуулан тооцож ажиллах;

В) Гүйцэтгэгч нь буулгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, фото зургийг захиалагчид хүлээлгэн өгнө.

ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

А) Ажил үйлчилгээний тоо хэмжээ, ажлын бодит үр дүнд дүйцүүлэн ажлын хөлсийг тооцож, санхүүжилтийг олгоно.

ЗАХИАЛАГЧААС ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ

А) Мэдээ, мэдээлэл: Захиалагчаас Гүйцэтгэгчид буулгалтын байршлын мэдээлэл, аюулгүйн тууз, холбогдох бичиг баримтын хуулбарыг өгнө. Дурдсан материалуудыг гүйцэтгэгчид түр хугацаагаар өгөх ба ажил дууссаны дараа эргүүлэн авна. Гүйцэтгэгчийг ажил үүргээ гүйцэтгэхээр бүтээн байгуулалтын ажлын нутаг дэвсгэрт нэвтрэх, ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тохиолдолд захиалагчаас зохицуулалт хийнэ.

ҮНИЙН САНАЛ АВАХ ХУУДАС

№	Байгууламжийн нэр	Хэмжих нэгж	Хэмжээ	Үнийн санал
1.	Бетонон суурьтай төмөр хашаа	Метр	1	
2.	Төмөр хашаа	Метр	1	
3.	Модон хашаа	Метр	1	
4.	Барилгын түр хашаа	Метр	1	
5.	Төмөр шон	Метр	1	
6.	Бусад	Метр	1	

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЛБАНЫ КАДАСТРЫН ХЭЛТСИЙН ДАРГА — Б.БАТЖАВХЛАН

НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЛБАНЫ ГАЗАР АШИГЛАЛТ, МОНИТОРИНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Г.АРИУНЗАЯА

НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЛБАНЫ САНХҮҮ, АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Д.АВИРМЭД

БОЛОВСРУУЛСАН:

НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЛБАНЫ САНХҮҮ, АЖ АХУЙН ХЭЛТСИЙН НЯГТЛАН БОДОГЧ — Г.СУВДАЙ

БАГЦ 1: ХАН-УУЛ ДҮҮРЭГТ ГАЗРЫН ЗӨРЧИЛ АРИЛГАХ (ХАШАА, ХАЙС) ЖАГСААЛТ

№	Дүүрэг	Хороо	Газар чөлөөлөх байршлын хаяг /гудамж, ойролцоох тодорхой барилга байгууламжийн нэр/	Хашааны материалын төрөл	Тоо хэмжээ /хашааны урт метрээр/
1	Хан-Уул	15	Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын зүүн талд Нархан хотхон	Бетон суурьтай төмөр хашаа	130
2	Хан-Уул	15	Рапид хороолол	Бетон суурьтай төмөр хашаа	419
3	Хан-Уул	15	Төв цэнгэлдэх урд	Төмөр	209
4	Хан-Уул	18	Удирдлагын академийн ард талд	Бетон суурьтай төмөр хашаа	79
5	Хан-Уул	19	75-р байрны баруун талд	Бетон хашаа	54
6	Хан-уул	19	79Б-р байрны баруун талд	Төмөр	55
7	Хан-Уул	19	115-р сургуулийн баруун тал	Бетон, блок, төмөр хашаа	67
8	Хан-Уул	19	115-р сургуулийн баруун талын хотхонуудын хашаа	Бетон, блок, төмөр хашаа	135

9	Хан-Уул	19	Дөл хотхоны орчим хашаа	Бетон, блок, төмөр хашаа	72
10	Хан-Уул	19	Дөл хотхоны орчим хашаа	Бетон, блок, төмөр хашаа	154
11	Хан-Уул	19	Дөл хотхоны орчим хашаа	Бетон, блок, төмөр хашаа	239
12	Хан-Уул	19	Үйлдвэр туул гол 44/1, Г44/2	Төмөр	62
13	Хан-Уул	19	Номин агуулах худалдаа байрлах газар	Төмөр	320
14	Хан-Уул	20	Яармагийн гүүрний зүүн талд	Бетон суурьтай төмөр хашаа	222
15	Хан-Уул	20	Яармагийн гүүрний зүүн талд	Бетон суурьтай төмөр хашаа	134
16	Хан-Уул	20	Аварга биеийн тамирын дэзд сургуулийн зүүн талд	Бетон суурьтай төмөр хашаа	158
17	Хан-Уул	20	80-р байрны баруун талд	Төмөр	45
18	Хан-Уул	24	Гурван тамир олон улсын дунд сургуулийн зүүн талд	Төмөр	250
Нийт 18 байршил 2804 метр (хашаа, хайс)					